



1.10 БУСАДТАЙ БАЙГУУЛСАН СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Компани олон нийтэд үнэт цаас санал болгон гаргах үйл ажиллагаатай холбогдуулан "Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох худалдах тухай журам"-д заасны дагуу "Монгол өмгөөлөгч" ХХК хууль зүйн фирмтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ 2011/04/20-ны өдөр байгуулан ажилласан. Уг гэрээний дагуу хуульчид компанийн холбогдох материалуудтай танилцсаны үндсэн дээр дараах чиглэлээр хараат бус дүгнэлт гаргасан.

ХУУЛИЙН КОМПАНИЙН ДҮГНЭЛТЭЭР

Дүрэм, журам, гэрээ, хэлцэл нь үнэт цаас гаргагчийн болон хөрөнгө оруулагчдын ашиг сонирхол, үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, СЗХ-оос тогтоосон журмуудад нийцэж байгаа эсэх талаар:
"Э-Транс Логистикс" ХХК-ийн дүрмийг компанийн тухай хуулийн холбогдох зүйл заалтад болон компанийн засаглалын кодекст нийцүүлж боловсруулсан байна.

Мөн компани олон нийтэд хувьцаагаа санал болгож, нээлттэй компани болох бэлтгэл ажлын хүрээнд "Э-Транс логистикс" ХК-ийн дүрэм болон компанийн засаглалын 5 журмын төслийг ирүүлсэн байна. Эдгээр баримт бичгийн төсөл нь Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд болон Компанийн засаглалын кодекст нийцэж, боловсруулагдсан байна.

Сүүлийн 3 жилд хийсэн хэлцлийн дотор их хэмжээний хэлцэл байгаа эсэх талаар:

Үнэт цаас гаргагч компани нь 2011 оны 12 сард үүсгэн байгуулагдснаас хойш ямар нэгэн их хэмжээний хэлцэл хийгээгүй байна.

Сүүлийн 3 жилд хийсэн хэлцлийн дотор сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх талаар:

Хууль зүйн компанийд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн гэрээнүүдээс дараах гэрээнүүд нь Компанийн тухай хуулийн 86 дугаар зүйлд зааснаар сонирхолын зөрчил бүхий хэлцлүүд байна.

- Э-Транс Логистикс ХХК болон Э-Транс ХХК-ийн хооронд байгуулсан газар эзэмших эрх шилжүүлэх гэрээ (2011/02/01)
- Э-Транс Логистикс ХХК болон Э-Транс ХХК-ийн хооронд байгуулсан үл хөдлөх эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (2011/02/01)
- Э-Транс Логистикс ХХК болон Э-Транс ХХК-ийн хооронд байгуулсан Зээлийн гэрээ (2011/04/19)

Эдгээр сонирхлын зөрчил бүхий хэлцлүүд нь Компанийн хуульд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөлөөсөө зөвшөөрөл авч, хуулийн дагуу байгуулагдсан байна.



Э-ТРАНС
ЛОГИСТИКС
ХК

